



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2008 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 401

Улаанбаатар хот

Гадаадад зээлээр суралцуулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам", шалгалтын комиссын дүн, захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энхбаатар овогтой Мөнхмаралыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар АНУ-ын Виржиния мужийн Жорж Майсоны Их сургуулийн магистрантурт төрийн удирдлагын чиглэлээр хоёр жилийн хугацаагаар, Зантив овогтой Занданг Мэдээллийн "МОНЦАМЭ" агентлагийн захиалгаар АНУ-ын Колорадо мужийн Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр хоёр жилийн хугацаагаар, Цагдаагийн ерөнхий газрын захиалгаар Загдсамбарын Гомбо, Идэрийн Батчулуун нарыг ОХУ-ын Дотоод явдлын яамны Удирдлагын академид хоёр жилийн хугацаагаар, Цэдэндамбын Амгалан-Энхийг мөн академийн адъюнктурт гурван жилийн хугацаагаар 2008-2009 оны хичээлийн жилээс тус тус Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчдтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



САЙД

Басгийн

Н.БОЛОРМАА

09-11-01